

ДОТООДЫН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**



2025.12.08

Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- ГВАН түүхэн дээд ханш болох 6 тэрбум ам.долларт хүрлээ.
- Гадаад худалдаа эхний 11 сард 23.9 тэрбум ам.доллар болж буурлаа.
- MFC хувьцааны ханш 4 жилийн түүхэн доол ханшиндаа хүрлээ.

МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	0.18%	0.92%	25.47%
MSE A	0.91%	-0.01%	20.27%
MSE B	0.92%	-0.97%	34.89%

2025/12/01 – 2025/12/05

Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Тоо ширхэг
MLG	2,505,797.00
MGLA	1,848,078.00
MFC	442,943.00
KHAN	400,710.00
MNDL	368,127.00

2025/12/01 – 2025/12/05

Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
DAH	22,800.00	34.60%
TUS	278.00	15.00%
MIK	13,910.00	15.00%
EER	5,395.00	14.85%
BAZ	1,998.00	9.78%

2025/12/01 – 2025/12/05

2025 он 12-р сарын 08

Зах зээлийн
үнэлгээ тэрбум ₮

13,234

ТОП-20 индекс

51,651

MSE A

19,609

MSE B

14,730



МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.6%

2025 - III улирал

Инфляц

9.2%

2025-10 сар

ГВУН(сая\$)

6,014.20

2025-11 сар

Бодлогын
хүү

12.0%

ЗГ-ын бондын
өгөөж

6.6%

USD/MNT

3,545.52


2025-12-05

 **Эдийн засгийн мэдээлэл****ГВАН ТҮҮХЭН ДЭЭД ТҮВШИН БОЛОХ 6 ТЭРБУМ АМ.ДОЛЛАРТ ХҮРЛЭЭ**

Монгол Улсын уул уурхайн бүтээгдэхүүний экспортын огцом өсөлт нь төлбөрийн тэнцэл болон гадаад худалдааны орлогыг нэмэгдүүлж, банкны системээр орж ирэх валютын урсгалыг хүчтэй нэмэгдүүллээ. Үүнтэй зэрэгцэн Засгийн газар, Монголбанк хоёр суурь эдийн засгийн нөхцөлтэй уялдуулан олон улсын зах зээлд гаргасан бондыг үр ашигтайгаар дахин санхүүжүүлж, өндөр хэмжээний гадаад зээлийн төлбөрүүдийг хугацаанд нь барагдуулж, өрийн удирдлагын бодлогоо амжилттай хэрэгжүүлсэн.

Эдийн засгийн энэ эерэг өөрчлөлт, зээлжих зэрэглэлийн өсөлт, гадаад санхүүжилтийн сайжирсан орчны үр дүнд 2025 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн байдлаар Монгол Улсын гадаад валютын нөөц 6014.20 сая ам.долларт хүрч, түүхэн хамгийн өндөр түвшинд хүрэв. Гадаад валютын нөөцийн өсөлт нь дотоодын эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, мөн Монголбанкны үндсэн зорилт болох төгрөгийн тогтвортой байдлыг хангахад чухал хувь нэмэр оруулж байна.

График 1. ГВАН график

**ГАДААД ХУДАЛДАА ЭХНИЙ 11 САРД 23.9 ТЭРБУМ АМ.ДОЛЛАР БОЛЖ БУУРЛАА**

Энэ оны эхний 11 сарын байдлаар Монголын экспорт өмнөх оны үзүүлэлтээс 850 сая ам.доллараар буурсан бол импортын хэмжээ 3.5 тэрбумаар өссөнөөр худалдааны тэнцэл сөрөг гарсан байна. Экспортын өсөлтийг голчлон зэсийн баяжмал бүрдүүлсэн бөгөөд энэ бүтээгдэхүүний экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 72.5 хувиар өсөж, нийт 5 тэрбум ам.доллар хүрсэн нь хамгийн том дэмжлэг болсон үзүүлэлт юм. Ингэснээр эхний 11 сард нийт экспортолсон 73.8 сая тонн чулуун нүүрсний орлогыг давсан дүн болж байна. Зэсийн баяжмалын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 34.8 хувиар өссөн нь экспортын нийт орлогод хүчтэй нөлөөлжээ.


Чулуун нүүрсний экспортын биет хэмжээ өмнөх оноос 0.3 хувиар буурсан ч үнэ өссөнөөр нийт орлого 4.9 тэрбум ам.доллар болсон байна. Төмрийн хүдрийн экспортын орлого 18.4 хувиар өссөн бол боловсруулсан нефтийн бүтээгдэхүүн болон алтны экспорт 13-19 хувиар буурсан үзүүлэлттэй гарлаа. Импортын хувьд гол өсөлтийг автозасварын сэлбэг, дизель түлш, нефтийн бүтээгдэхүүн болон тоног



Зах зээлийн мэдээлэл

МОНОС ХҮНС ХК ХУВЬЦААНЫ ХАНШ 4 ЖИЛИЙН ДООД ТҮВШИНД ХҮРЛЭЭ

График 2. MFC хувьцааны ханшийн график




Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх өнгөрсөн 11 дүгээр сард “Хүнсний хувьсгал” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монос Хүнс ХК-ийн MFC 2.0 нэгдсэн үйлдвэрийн шинэ бүтээн байгуулалттай газар дээр нь танилцлаа. Тус компани 30 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлээр үйлдвэр, агуулах, тоног төхөөрөмжийн өргөтгөл хийж, үйлдвэрлэлийн хүчин чадлаа гурав дахин нэмэгдүүлсэн бөгөөд борлуулалтын орлого 2022 оныхоос 68% өссөн, ажилчдын цалин 50% нэмэгджээ. Мөн хуванцар савлагааны хэрэглээг жилд 172 тонн хүртэл бууруулсан байна.

Гэвч эдгээр бодит өсөлт, үйлдвэрлэлийн өргөтгөл, нийгмийн хариуцлагын олон төсөл хэрэгжсэн ч Монос Хүнс ХК-ийн хувьцааны ханш сүүлийн 4 жилийн доод түвшинд хүрээд байна. Үйлдвэрлэлийн зэрэг өөрчлөлт богино хугацаанд зах зээлийн үнэлгээнд шууд нөлөөлж чадалгүй, хөрөнгө оруулагчдын хүлээлт болон нийт зах зээлийн орчны нөлөө давамгайлж буйг шинжээчид онцолж байна.

2025 онд MFC 2.0 үйлдвэр ашиглалтад орсноор компанийн дунд хугацааны өсөлтийн потенциал сайжирсан ч ханшийн өнөөгийн сул хөдөлгөөнд зах зээлийн нийт эрэлт, хөрвөх чадвар, жижиг хөрөнгийн зах зээлийн цикл илүү хүчтэй нөлөөлж байгаа дүр зураг харагдаж байна.

ТОП-20 ИНДЕКС ОНЫ СҮҮЛИЙН ХАГАСТ ӨСӨЛТТЭЙ БАЙНА


График 3. ТОП-20 индексийн ханшийн график



ТОП-20 индекс 2025 оны эхний улиралд түүхэн дээд ханш болох 54,018-д хүрсэн билээ. Өнөөдрийн байдлаар 51,651 байгаа бөгөөд оройн цэгээсээ 4.4 хувиар ойролцоогоор унасан дүр зурагтай байна.

ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.

ВАЛЮТЫН ХАНШИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Хэрэв нүүрсний үнэ 10%-иар буурч экспортын орлого 800 сая ам.доллараар багасна гэж үзвэл: 2026 онд инфляц 0.7 нэгж хувиар нэмэгдэхтэй уялдан төгрөгийн ханш ам.долларын эсрэг 3-5% орчим сулрах магадлалтай.

График 1. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш

